



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 402

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.6, аймгийн Онцгой комиссын 2020 оны 21 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төв, Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудад оторлож байгаа малчидтай уулзах ажлын хэсгийн шатахууны зардал, отрын малчдад олгох эмийн багц 8,214,000 (Найман сая хоёр зуун арван дөрвөн мянга) төгрөг, Бүрд суманд оторлож байгаа өрхүүдэд нүүрсний дэмжлэг үзүүлэх тээврийн зардал 660,000 (Зургаан зуун жаран мянга) төгрөг нийт 8,874,000 (Найман сая найман зуун далан дөрвөн мянга) төгрөгийн зардлын хуваарилалтыг хавсралтаар баталсугай.

2. Бүрд суманд оторлож байгаа малчин өрхүүдэд нүүрс тараах ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т үүрэг болгосугай.

3. Дээрх зардлыг аймгийн гамшгаас хамгаалах эрсдлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын (Санхүү, төрийн сангийн хэлтэс)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



011100003

Аймгийн Засаг даргын 2021 оны 01
дугаар сарын 05-ны өдрийн 10 дугаар
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Арга хэмжээний нэр	Малчин өрхийн тоо	Нийт үнэ (төгрөг)
1	Гадны аймагт отроор яваа малчдыг эргэх ажлын хэсгүүдийн шатахууны зардал, эмийн багцын үнэ	230	8,214,000
2	Бүрд суманд өөрийн аймгийн өөр сумаас оторлож байгаа малчин өрхүүдэд нүүрс хүргэх тээврийн зардал	66	660,000
			8,874,000

-оОо-